



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/748

Булган сум

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн
үед авах арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 147 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 373 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2025 оны 07, 08 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Томуу, томуу төст өвчний дэгдэлт аймгийн хэмжээнд улаан түвшинд хүрсэн тул өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг уртасгасан цагаар ажиллуулсугай.

2.Аймаг, сум, багийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах, нийтийг хамарсан сургалт, соёл урлаг, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, багш, сурагчдыг хамарсан урлаг, спортын уралдаан тэмцээн болон хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааг 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд зогсоож, урлагийн танхим, спорт заалыг бусдад ашиглуулахыг хориглосугай.

3.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж амны хаалт зүүх, халдвар хамгааллын дэглэм барих, ариутгал халдваргүйтгэлийг хийж ажиллах, төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны байгууллагуудад заавар, зөвлөмжийг бэлтгэн гаргах, гэрийн эмчилгээтэй байгаа амьсгалын замын өвчлөлтэй иргэдийн эргэлтийн үзлэг хяналтыг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг)-т, мэдээллийг олон нийтэд түгээж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Э.Эрболд)-нд тус тус даалгасугай.

4.Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 0-12 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарч байгаа эцэг, эх, асран хамгаалагчид холбогдох хууль, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн сум, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ажлын тав хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгох, цахимаар ажиллуулах эсхүл ажлын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлж ажиллахыг сумын Засаг дарга болон төрийн байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгож, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын захирал, удирдлагад зөвлөсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



0325011143